

# Нийлбэр нь тэг

Өсөхөөр эрэмблэгдсэн 1-N (N=9) хүртэлх цифрүүдийн дараалал: 1 2 3 ... N өгөгджээ.

Цифрүүдийн хооронд нэмэх үйлдэл хийхийн тулд '+', хасах үйлдэл хийхийн тулд '-', цифрүүдийг нийлүүлэн нэг тоо үүсгэе гэвэл хоосон ' ' тэмдэгт нэмж оруул(эхний цифрийн өмнө тэмдэгт оруулахгүй). Үүссэн илэрхийллийг бодож үр дүн нь 0 гарч байгаа эсэхийг шалга.

N урттай нийлбэр нь 0 байх бүх дарааллуудыг олох програм бич.

**Программын нэр: zerosum**

**Оролтын формат:**

Нэг мөрөнд N тоо байна. ( $3 \leq N \leq 9$ ).

**Жишээ оролт (файл zerosum.in)**

7

**Гаралтын формат**

Нийлбэр нь 0 байх бүх дарааллуудыг цифрүүдийн хооронд '+', '-', ' ' оруулан ASCII дарааллын дагуу харуул.

**Жишээ гаралт(файл zerosum.out)**

1+2-3+4-5-6+7

1+2-3-4+5+6-7

1-2 3+4+5+6+7

1-2 3-4 5+6 7

1-2+3+4-5+6-7

1-2-3-4-5+6+7

Орчуулсан : Б.Даваабаяр